Онцгой байдлын газар, урьдчилан сэргийлэх тасаг, Гал түймэр унтраах, аврах 16 дугаар анги, Гал түймэр унтраах, аврах 72 дугаар анги, Жаргалант сум дахь Эрэн хайх аврах салбар, Улсын нөөцийн 127 дугаар салбар, Баянхонгор сум дахь Эрэн хайх, аврах бүлэг, Баянцагаан сум дахь эрэн хайх, аврах бүлэг, Баянговь сум дахь Эрэн хайх, аврах бүлэг зэрэг бүтэц зохион байгуулалтай, батлагдсан орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ОБЕГ-ын даргын 2016.12.15-ний өдрийн А/293 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна..

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 4,391,914.9 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 133,459.6 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	52,772.0	52,772.0
Авлага	30,000.0	30,000.0	-
Бараа материал	1,013,427.9	1,141,785.3	128,357.3
Үндсэн хөрөнгө	6,450,063.3	7,105,987.8	655,924.5
Хуримтлагдсан элэгдэл	(3,235,035.9)	(3,938,630.2)	(703,594.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,258,455.4</b>	<b>4,391,914.9</b>	<b>133,459.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,258,455.4	4,391,914.9	133,459.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,258,455.4</b>	<b>4,391,914.9</b>	<b>133,459.6</b>

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Авлага дансны үлдэгдэл 30,000.0 мянган төгрөг байгаа нь 2016 онд үүссэн Сод ноён ХХК-тай холбоотой үүсэн авлага тус байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн боловч Баянхонгор аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 1/2955 дугаартай шинжгүй гэж дүгнэн 2022 оны 184 тогтоолоор хэрэг бүртгэлийг хаасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,141,785.3 мянган төгрөг болж 128,357.3 мянган төгрөг өссөн нь төсвийн хөрөнгөөр 206,768.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн ЗДТГ болон аймгийн онцгой комиссоос 7,712.5 мянга, аймгийн ИТХ-аас 9,800.0 мянга, Онцгой байдлын Ерөнхий газраас 438,274.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авч 521,111.4 мянган төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 8,020.0 мянган төгрөгийг хөрөнгийн төсөвт байгууллагад шилжүүлэн, 5,067.1 мянган төгрөгийн Онцгой байдлын газрын даргын 2024 оны А/71 дүгээр тушаалаар акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,105,987.8 мянган төгрөг болж 655,924.5 мянган төгрөгөөр өссөн нь 904.9 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 185 дугаар ангиас 149,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Ланд Круйзер Лонг-76 автомашин, Ар тал хангалтын 115 дугаар ангиас Баянговь, Баянцагаан Эрэн хайх, аврах бүлгүүдэд шуурхай албаны зориулалт бүхий ISUZU маркийн 398,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг тээврийн хэрэгсэл, аймгийн Засаг даргын Тамгын газраас 10,500.0 мянга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 8,000.0 мянга, ОБЕГ-н харьяа ар талын 115 дугаар ангиас 16,934.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,391,914.9 мянган төгрөг болж 133,459.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 133,459.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,234,485.9 мянган тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 510,643.4 мянган төгрөгөөр өсгөж 3,745,129.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 4,080,491.7 мянган төгрөг болгож 335,362.4 мянган төгрөгөөр өсгөн баталсан нь төрийн албан хаагчийн цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,080,491.7 мянган төгрөг батлагдсанаас 4,046,832.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,046,832.2 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 33,659.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80801 үндсэн үйл ажиллагаа зардал	4,072,179.9	4,038,532.2	33,647.7	99%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	8,311.8	8,300.0	11.8	100%
	Нийт дүн	4,080,491.7	4,046,832.2	33,659.5	99%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 33,647.7 мянга буюу 1 хувь, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 11.8 мянга нийт 33,659.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дараах орлого төвлөрсөн байна.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого

Д/д	Орлогын нэр төрөл	Авсан санхүүжилт
1	Гамшгийн голомтот ажилласан томилот *	9,535.5
2	УНС-ын засварын зардал	12,000.0
3	Даатгалын нөхөн төлбөр	3,503.5
4	Баянхонгор аймгийн Нисэх буудлаас Галын машины түрээсийн төлбөр	3,300.0
5	Онцгой байдлын газар /Ахмадын сан байгуулав.	52,772.0
	Нийт дүн	81,111.0

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орлогыг зориулалтын дагуу зарцуулсан ба оны эцэст ахмадын сан байгуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 52,772.0 мянган төгрөгийг төвлөрүүлж 52,772.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ирүүлсэн.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Д.Бат-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Э.Баянзул нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зардлын 3,745,129.3 мянган төгрөгөөс тооцоход 37,451.3 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 24,343.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2024 оны гэрэл цахилгааны зардлыг 7,285.0 мянга, түлш халаалтын зардлыг 3,073.8 мянга, цэвэр бохир усны зардлыг 198.0 мянга нийт тогтмол зардал 10,556.8 мянга буюу 5.5 хувь хэмнэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,061,752.3 мянган төгрөгийн 32 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 315,041.4 мянган төгрөгийн 26 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 159,211.3 мянган төгрөгийн 120 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Харин цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 40,044.2 мянган төгрөгийн 1 гүйлгээ байршуулаагүй байсан ба аудитын явцад нөхөн мэдээлсэн.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар 36,052.2 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 354.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,791.0 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 30,907.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын даргын 2024.02.29-ны өдрийн 18/57 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг тооцсон ба 1 зөвлөмж хэрэгжээгүй хэрэгжилтийг 75 хувиар тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	354.1	1	354.1	100
Албан шаардлага	1	4,791.0	1	4,791.0	100
Зөвлөмж	2	30,907.1	1	907.1	50
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>36,052.2</b>	<b>3</b>	<b>6,052.2</b>	<b>75.0</b>

Эх сурвалж: 2024 оны аудитын тайлангаас

Өмнөх оны аудитаар өгсөн 30,000.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 67,145.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 67,145.1 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

#### 5.1 Албан шаардлага

1. Тус байгууллага нь 2024 оны 09 сард урсгал засварын зардлаас "Арвижих" барилгын материалын дэлгүүртэй 19,908.0 мянган төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Гал түймэр унтраах, аврах 16 ангийн дээврийн засвар, "Дэлгэрэх" барилгын материалын дэлгүүртэй 17,237.1 мянган төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, 72 дугаар ангийн байранд ариун цэврийн өрөө нойлын засварын хийсэн гэх боловч дээрх ажлууд нь засварын ажлын зураг төсөв байхгүй барилгын материал худалдан авч шаардах хуудсаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйл. Төсвийн зарлага 24.6 дахь "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

**"Шийдвэрлэсэн нь:** Гал түймэр унтраах, аврах 16 ангийн дээврийн засвар, Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, 72 дугаар ангийн байранд ариун цэврийн өрөө нойлын засварын ажлыг хийсэн талаарх нотлох баримтыг ирүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд 2016 онд "Сод ноён" ХХК-тай холбоотой үүссэн авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь " Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. " гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** "Сод ноён" ХХК-тай холбоотой үүссэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь 2024 оны 09 сард урсгал засварын зардлаас "Арвижих" барилгын материалын дэлгүүртэй 19,908.0 мянган төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Гал түймэр унтраах, аврах 16 ангийн дээврийн засвар, "Дэлгэрэх" барилгын материалын дэлгүүртэй 17,237.1 мянган төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, 72 дугаар ангийн байранд ариун цэврийн өрөө нойлын засварын хийсэн гэх боловч дээрх ажлууд нь засварын ажлын зураг төсөв байхгүй барилгын материал худалдан авч шаардах хуудсаар зарцуулсан байна	1	37,145.1	-	-	1	37,145.1	-	-
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын санхүүгийн тайланд 2016 онд "Сод ноён" ХХК-тай холбоотой үүссэн авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	30,000.0	-	-	1	30,000.0	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>67,145.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>67,145.1</b>	<b>-</b>	<b>-</b>

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 05/АО 570240 / АНА-2025/038/  
НА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урсгал засварын зардлаас 2024 оны 9 сард "Арвижих" барилгын материалын дэлгүүртэй 19,908,000 (Арван есөн сая есөн зуун найман мянга) төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Гал түймэр унтраах, аврах 16 ангийн дээврийн засвар, "Дэлгэрэх" барилгын материалын дэлгүүртэй 17,237,100 (Арван долоон сая хоёр зуун гучин долоон мянга нэг зуу) төгрөгийн барилгын материал нийлүүлэх гэрээ байгуулж Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, 72 дугаар ангийн байранд ариун цэврийн өрөө нойлын засварын хийсэн гэх боловч дээрх ажлууд нь зураг төсөв байхгүй барилгын материал худалдан авч шаардах хуудсаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйл Төсвийн зарлага; 24.6 дахь "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх" 13 дугаар зүйлийн 13.5 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага

5040013

өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гал түймэр унтраах, аврах 16 ангийн дээврийн засвар, Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах, 72 дугаар ангийн байранд ариун цэврийн өрөө нойлын засварын ажлыг хүлээн авах комисс томилон хүлээн авч нотлох баримтыг 2025 оны 03 сарын 14 дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Э.Баянзул нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

*Н.Бунчинсүрэн*

6417143544  
60A0067 9007423

Н.БҮНЧИНСҮРЭН

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана.”

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 06/А0570 240 /АМА-20257038/  
НА-СТА-ТМЗ

Номгон

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд 2016 онд үүссэн "Сод ноён" ХХК-тай холбоотой 30,000,000 (Гучин сая) төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.1.10 дахь "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланд үлдэгдэлтэй байгаа Сод ноён ХХК-тай холбоотой 30,000,000 (Гучин сая) төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2025 оны 05 сарын 30 дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

5040018

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Э.Баянзул нарт даалгав<sup>1,2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

*Handwritten signature*

Н.БУНЧИНСҮРЭН

6417143544  
Б.ОА0067 9007423

<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно